СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/09/-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 7
4. АУДИТЫН ТАЙЛАН 10
4.1 Ерөнхий зүйл 10
4.2 Материаллаг байдал 10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд 11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 12
4.5.1 Завсрын аудитын талаар 12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 12
5.1 Төлбөрийн акт 13
5.2 Албан шаардлага 13
5.1 Зөвлөмж 14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчид аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

"ТӨГӨЛДӨР ЕРӨӨ" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.УРТНАСАН ТАНАА

2024.03.15 № СӨА-2024/09/-НА-ОТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон **2,635.0** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын 2023 оны 97 дугаар тогтоолоор тус газрын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж, 2023 оны нийт зардал өмнөх оноос 63.7 хувиар нэмэгдсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 34 дүгээр тогтоолоор баталсан тус газрын дүрэмд заасан хог хаягдал, ногоон байгууламж, зам талбай, гэрэлтүүлэг зэрэг үйл

C18022331

ажиллагаанд сумын ЗДТГ-аас 201,300.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөөгүй болон орон тооны эд хариуцагчгүй ажиллаж байгаа нь нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль, журмын дагуу үнэн зөв хөтлөхгүй, тайлан, тодруулга алдаатай илэрхийлэгдэх нөхцөл болж байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 97 дугаар тогтоолоор "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайланг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	**Эргэлтийн хөрөнгө**	**-**	**-**
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,118,224.09	20,166,277.52
1.1.4	Бусад авлага	141,886.71	141,886.71
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**2,260,110.80**	**20,308,164.23**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,026,166.67	15,816,167.33
1.2.9	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**12,026,166.67**	**15,816,167.33**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**14,286,277.47**	**36,124,331.56**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	**-**	**-**
2.1	**Өр төлбөр**	-	-
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**	-	-
2.1.1.1	Дансны өглөг	806,246.11	806,246.11
2.1.1.3	Татварын өр	-	4,732,978.88
2.1.1.12	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**806,246.11**	**5,539,224.99**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**806,246.11**	**5,539,224.99**
2.3	**Эздийн өмч**	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	13,480,031.36	30,585,106.57
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**13,480,031.36**	**30,585,106.57**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**14,286,277.47**	**36,124,331.56**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**Борлуулалтын орлого (цэвэр)**	**267,767,600.00**	**409,607,075.88**
2	**Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**	**-**	**390,601,436.76**
3	**Нийт ашиг (алдагдал)**	**267,767,600.00**	**19,005,639.12**
8	Бусад орлого	270,000.00	-
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	112,114,600.00	-
12	Бусад зардал	275,086,300.00	-
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**-119,163,300.00**	**19,005,639.12**
19	Орлогын татварын зардал	-	1,900,563.91
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**-119,163,300.00**	**17,105,075.21**
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**-119,163,300.00**	**17,105,075.21**
23	**Бусад дэлгэрэнгүй орлого**	**-**	**-**
24	**Нийт дэлгэрэнгүй орлогын дүн**	**-119,163,300.00**	**17,105,075.21**
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн

1.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	113,543,300.00	113,543,300.00
2. Залруулсан үлдэгдэл	**-**	**-**	**121,423,300.00**	**121,423,300.00**
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-119,163,300.00	-119,163,300.00
8.Эхний үлдэгдэл	-	-	**2,260,000.00**	**2,260,000.00**
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	2,260,000.00	2,260,000.00
10. Залруулсан үлдэгдэл	**-**	**-**	**13,480,031.36**	**13,480,031.36**
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	17,105,075.21	17,105,075.21
16. Эцсийн үлдэгдэл	**-**	**-**	**30,585,106.57**	**30,585,106.57**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	**Мөнгөн орлогын дүн**	**268,037,600.00**	**450,567,783.48**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	267,767,600.00	450,567,783.38
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	270,000.00	-
1.2	**Мөнгөн зарлагын дүн**	**274,408,400.00**	**426,831,030.05**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	75,269,300.00	137,758,059.47
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,374,100.00	40,509,056.49
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	116,751,000.00	62,124,580.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,726,300.00	12,977,388.71
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	33,332,400.00	116,209,899.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	332,000.00	39,054,746.38
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,623,300.00	18,197,300.00
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-6,370,800.00**	**18,048,053.43**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	-	-
2.2	**Мөнгөн зарлагын дүн**	-	**5,688,700.00**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	5,688,700.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	-	**-5,688,700.00**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	-	-
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**-6,370,800.00**	**18,048,053.43**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	8,489,000.00	**2,118,224.09**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	2,118,224.09	**20,166,224.09**
	БЦМГ /1,3+2,3+3,3+4/	**-6,370,800.00**	**18,048,053.43**
	БЦМГ /6-5/	**-6,370,800.00**	**18,048,053.43**
	Зөрүү	-	-

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	**Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт**					

2	**Нийт орлого**	**268,679,100.00**	**446,577,600.00**	**450,567,783.48**	**3,990,183.48**	**100.89**
	Үүнээс: Цэвэр борлуулалт	190,076,900.00	446,577,600.00	409,607,075.88	-36,970,524.12	91.72
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	78,602,200.00	0.00	0.00	-	
3	**Нийт зардал**	**275,049,550.00**	**439,741,600.00**	**433,462,663.27**	**-6,278,936.73**	**98.57**
	Үүнээс: а) Борлуулалт, маркетингийн зардал	195,786,850.00	252,484,100.00	214,234,884.71	-38,249,215.29	84.85
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	79,262,700.00	187,257,500.00	178,267,115.96	-8,990,384.04	95.20
	в) Хөрөнгө оруулалт их засвар	0.00	0.00		-	
4	**Цэвэр ашиг, алдагдал**	**-6,370,450.00**	**6,836,000.00**	**17,105,075.21**	**10,269,075.21**	**250.22**

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Сумын ИТХ-ын 2013 оны 16 дугаар тогтоолд 2021 оны 34 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж тус газрын дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэвээр баталжээ.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сумын төв дэх орон нутгийн өмчит худалдааны төв, халуун ус, ахуйн үйлчилгээг удирдлага зохицуулалтаар хангах,
- Сумын төв дэх нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг гүйцэтгэх, хяналт тавих,
- Сумын төв дэх авто зам болон явган хүний зам, нийтийн зам талбай, тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулах болон засвар, үйлчилгээг хариуцах,
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, давхин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагааг сумын хэмжээнд зохих хууль, журам, зааврын хүрээнд эрхлэх,
- Дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг зохих хуулийн хүрээнд эрхэлж дулаан хэрэглэгчдийг хангаж хариуцан ажиллах гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж юм.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ нь Ерөө сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолоор байгуулагдсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд "Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх" 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д " *Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах*", Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д *"Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих*" гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Ерөө сумын ИТХ, ЗДТГ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг ***аккруэл*** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөөгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,838.2 мянган төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,118.20	20,166.30	18,048.10
Авлага	141.90	141.90	0.00
Бараа материал	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	12,026.10	15,816.20	3,790.10
Нийт хөрөнгийн дүн	**14,286.20**	**36,124.40**	**21,838.20**
Өр төлбөр	806.20	5,539.20	4,733.00
Эздийн өмч	13,480.00	30,585.10	17,105.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**14,286.20**	**36,124.30**	**21,838.10**

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 20,166.3 мянган төгрөг болж 18,048.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 17,105.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,539.2 мянган төгрөг болж 4,733.0 мянган төгрөгөөр өссөн нь татварын өр 4,733.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 97 дугаар тогтоолоор ""Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталж, нийт орлогыг 446,577.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 439,741.6 мянган төгрөгөөр, ашгийг 6,836.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 450,567.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 433,462.7 мянган төгрөгийн зардал гарган, 17,105.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант оны орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аж ахуйн нэг байгууллагаас халаалт, усны орлого 238,749.0 мянган төгрөг,
- Сумын ОНХС-аас мал зүйчийн цалингийн зардалд 10,518.7 мянган төгрөг,
- Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд 20,000.0 мянган төгрөг,
- Хог хаягдлын татаас 90,000.0 мянган төгрөг,
- Ногоон байгууламжийн засвар үйлчилгээнд 20,000.0 мянган төгрөг,
- Зам, талбайн засвар үйлчилгээнд 71,000.0 мянган төгрөг,

- Бусад 300.0 мянган төгрөг зэрэг.

Нийт орлогын гүйцэтгэл 450,567.7 мянган төгрөг болж төлөвлөгөөг 3,990.2 мянган төгрөг буюу 0.9 хувиар давуулан биелүүлсэн нь халаалт, усны орлогын гүйцэтгэлээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 433,462.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 6,278.9 мянган төгрөг буюу 1.4 хувиар хэмнэсэн нь нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал гаргаагүйтэй холбоотой байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны мэдээлэл, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 263,497.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **2,635.0** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

"Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж бичиг хэргийн зардлыг хэмнэсэн,
- Албан конторын их засварын ажлыг хийгээгүй,
- Албан томилолтын зардал гаргалгүй хэмнэсэн зэрэг.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 163 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа,
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг 6 удаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шууд худалдан авах босго үнээс давсан 56,149.2 мянган төгрөгийн нүүрс, 46,089.7 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "*Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална*",

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2: *"Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн *"Төгөлдөр Ерөө"* ОНӨААТҮГ-ын шилэн дансны мэдээлэл болон худалдан авах ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн акттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 124 дүгээр "Санхүүгийн тайланд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дулаанаар хангах үйл ажиллагаа явуулсан гэсэн албан шаардлагын биелэлтийг хангахаар Сэлэнгэ аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлд 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар албан бичгээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт, холбогдох материалыг хүргүүлсэн тул биелэлтийг 100.0 хувиар тооцлоо.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		100.0
Нийт дүн	**1**		**1**		**100.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **156,958.0** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулаа. Үүнд:

- 148,210.5 мянган төгрөгийн бараа материалын ажил гүйлгээ, журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй,

- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад 5,688.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тусгаагүй,
- Санхүүгийн байдлын тайлан, өр төлбөрийн тодруулгад 3,058.8 мянган төгрөгийн татварын өрийг тусгаагүй,

Аудитаар нийт **17,511.9** мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 477.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17,034.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Механикч М.Мөнхжаргалын ээлжийн амралтын цалинг зөрүүтэй тооцож, **477.7** мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.2-т *"Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.* 20.2.5: *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Сумын Засаг даргын 2023 оны Б/13 дугаар захирамжийн дагуу тус газрын дүрэмд заагдаагүй "Ерөө сумын үржлийн нэгж"-ийн үйл ажиллагааг эрхэлж, мал зүйчийн цалингийн зардалд **10,518.7** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх "*Өөрт олгогдсон хөрөнгийг **дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн** эзэмших, ашиглах",* Ерөө сумын ИТХ-ын 2021 оны 34 дүгээр тогтоолоор баталсан "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ-ын дүрмийн 4.1-т заасан үйл ажиллагааны чиглэлтэй тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Байгууллагын дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэл эрхэлж, санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй болон анхан шатны баримтын бүрдэлгүйгээр дараах **6,515.5** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Дарга, нягтлан бодогч нарын хувийн дансаар дамжуулан 4,976.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, мөнгөн кассын тайлан гаргаагүй,
- Төлбөрийн нэхэмжлэх, зарлагын баримт, цахим төлбөрийн баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 1,539.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,*

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7 дахь *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөөгүйгээс бараа материалын ажил гүйлгээ, журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дараалын дагуу гүйцэтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь *"Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ, 14.3.1: Анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2: Журналд бичих, 14.3.3: Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4: Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5: Санхүүгийн тайлан гаргах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын ажил гүйлгээг холбогдох хууль, журам, стандартын дагуу бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[2] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын ажил гүйлгээ, журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй	1	148,210.5	1	148,210.5			1	148,210.5				
Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад үндсэн хөрөнгийг тусгаагүй	1	5,688.7	1	5,688.7			1	5,688.7				
Санхүүгийн байдлын тайлан, өр төлбөрийн тодруулгад татварын өрийг дутуу тусгасан	1	3,058.8			1	3,058.8	1	3,058.8				
Дүн	**3**	**156,958.0**	**2**	**153,899.2**	**1**	**3,058.8**	**3**	**156,958.0**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин зөрүүтэй тооцож олгосон	1	477.7	1	477.7								
Байгууллагын дүрэмд заагаагүй "Ерөө сумын үржлийн нэгж"-ийн үйл ажиллагаа эрхэлж, санхүүжүүлсэн	1	10,518.7			1	10,518.7						

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	6,515.5			1	6,515.5						
Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй	1						1					
Дүн	**4**	**17,511.9**	**1**	**477.7**	**2**	**17,034.2**	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	102,238.9					1	102,238.9
Дүн	**1**	**102,238.9**					**1**	**102,238.9**
Нийт дүн	**2**	**102,238.9**					**2**	**102,238.9**